

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

/2021 оны жилийн эцсийн байдлаар/

2022.01.14

Дархан

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, хүрсэн түвшинг тусгагдсан зорилт, арга хэмжээний зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор гүйцэтгэлээ.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn –ийн “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” цэсэнд байршсан 15 зорилтын 17 арга хэмжээ, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн нэгтгэсэн тайлан, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5 дугаар бүлгийн 5.1.2-т заасны дагуу боловсруулалтыг сайжруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээлэл, баримт, материалыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтсийн асуудал хариуцсан албан хаагчдаас тодруулга авах, санал солилцох, ярилцлагын аргаар, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу гүйцэтгэлээ.

Хяналтанд авсан шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2.2 дахь заалтын дагуу хэрэгжилтийг хувиар тооцож гаргалаа.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2021 оны жилийн эцсийн байдлаар Дархан-Уул аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

Эдийн засгийн бодлогын 4 зорилтын 4 арга хэмжээ,
Засаглалын бодлогын 2 зорилтын 4 арга хэмжээ,
Ногоон хөгжлийн бодлогын 3 зорилтын 3 арга хэмжээ,
Орон нутгийн хөгжлийн бодлогын 6 зорилтын 6 арга хэмжээ,

нийт **15 зорилтын 17 арга хэмжээг** хяналтанд авч, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Гурав. Дүгнэлт

2021 оны жилийн эцсийн байдлаар Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний **15 зорилтын** хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **97.70%** буюу **4.88** онооны үнэлгээгээр үнэлэгдлээ.

№	Хэрэгжилт	Бүгд	Бодлогоор, үүнээс			
			III. Эдийн засгийн бодлого	IV. Засаглалын бодлого	V. Ногоон хөгжлийн бодлого	VI. Орон нутгийн хөгжлийн бодлого
1.	Хяналтанд авсан нийт зорилтын тоо	15	4	2	3	6
2.	Үүнээс	100.0%	3	2	3	5
		70-99.0%	2	-	-	1
		31-69.0%	-	-	-	-
		0-30.0%	-	-	-	-
Хэрэгжилтийн дундаж хувь, оноо		97.70% буюу 4.88 оноо	92.50% буюу 4.62 оноо	100% буюу 5.0 оноо	100% буюу 5.0 оноо	98.33% буюу 4.91 оноо

17 арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээгээр **97.64** хувийн хэрэгжилттэй **4.88** онооны үнэлгээгээр тус тус үнэлэгдсэн байна.

№	Хэрэгжилт	Бүгд	Бодлогоор, үүнээс			
			III. Эдийн засгийн бодлого	IV. Засаглалын бодлого	V. Ногоон хөгжлийн бодлого	VI. Орон нутгийн хөгжлийн бодлого
1.	Хяналтанд авсан нийт зорилтын тоо	15	4	2	3	6
2.	Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо	17	4	4	3	6
3.	Үүнээс	100.0%	3	4	3	5
		90.0%	1	-	-	1
		70.0%	1	-	-	-
		50.0%	-	-	-	-
Хэрэгжилтийн дундаж хувь, оноо		97.64 % буюу 4.88 оноо	92.50% буюу 4.62 оноо	100% буюу 5.0 оноо	100% буюу 5.0 оноо	98.33% буюу 4.91 оноо

Холбогдох зохицуулах салбарын зорилт, арга хэмжээгээр харуулбал:

- ✓ Эдийн засгийн бодлогын 4 зорилтын 4 арга хэмжээний хэрэгжилт 92.50%,
- ✓ Засаглалын бодлогын 2 зорилтын 4 арга хэмжээний хэрэгжилт 100%,

- ✓ Ногоон хөгжлийн бодлогын 3 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 100%,
- ✓ Орон нутгийн хөгжлийн бодлогын 6 зорилтын 6 арга хэмжээний хэрэгжилт 98.33%-ийн үнэлгээтэй байна.

№	Хэрэгжилт	Бүгд	Хэрэгжүүлэх хэлтэс /агентлаг/, үүнээс					
			ТЗУХ	ХОХБТХ	НБХ	СТСХ	Цэргийн штаб	Захирагчийн алба
1.	Хяналтанд авсан нийт зорилтын тоо	15	1	8	2	1	1	2
2.	Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо	17	1	8	2	1	3	2
3.	100.0%	15	1	6	2	1	3	2
	90.0%	1	-	1	-	-	-	-
	70.0%	1	-	1	-	-	-	-
	50.0%	-	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийн хувь, оноо		97.64% буюу 4.88 оноо	100% буюу 5.0 оноо	95.0% буюу 4.75 оноо	100% буюу 5.0 оноо	100% буюу 5.0 оноо	100% буюу 5.0 оноо	100% буюу 5.0 оноо

Дөрөв. Хэрэгжээгүй шалтгаан, цаашид хэрэгжүүлэх гарц шийдлийн санал:

1. Эдийн засгийн бодлогод хамаарах 70.0% үнэлэгдсэн арга хэмжээний хувьд: 3.7.4 зорилтын Арга хэмжээ 5. “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулна”
Тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа: Дархан-Уул аймгийн 4 сумаас 3 буюу Дархан, Шарын гол, Орхон сумдууд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.
Хэрэгжээгүй шалтгаан нь: Хонгор сум нь “Сум нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулж 2022 онд сум хөгжүүлэх сангийн 67 сая.төгрөгийн хөрөнгөөр хийлгэх саналыг хүргүүлсэн боловч батлагдаагүй байна. Санхүүжилтийн асуудал /67.0 сая/
Гарц, шийдэл: Хөрөнгийн асуудлыг сум хөгжүүлэх сангийн төсвийн төсөлд суулган, шийдэгдвэл 2023 оноос хэрэгжих боломжтой,
2. Орон нутгийн хөгжлийн бодлогод хамаарах 90.0% үнэлэгдсэн 6.2.8 зорилтын Арга хэмжээ 1. “Инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах замаар аймаг бүрт гэр хорооллын 600-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцлийг сайжруулна”
Тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа: Аймгийн хэмжээнд төрийн 4 байгууллага, нийт 3594 айл өрх төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдох боломж бүрдсэнээс 2021 онд 60 айл бүрэн холбогдсон.
Хэрэгжээгүй шалтгаан нь: Дархан сум, 3 дугаар баг Тосгон чиглэлийн дулаан, цэвэр, бохир усны төв шугам, дулааны насос станц 1, ус дулаан дамжуулах төвийн

барилга, дулаан механик ажлыг Өгөөмөр баян булаг ХХК 70 хувийн гүйцэтгэлтэйгээр хийж 2022 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа.

Дархан сумын 6, 7 дугаар багийн гэр хорооллын төв магистрал шугамын ажлын нийт дулааны шугам 4298 хос метр, бохир усны шугам 3880м, цэвэр усны шугам 470м, 12 ширхэг ус дулаан дамжуулах төвийн барилга, 1 насос станцын барилга, дулаан механикийн угсралтын ажлыг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр улсын комисс бүрэн ашиглалтад хүлээн авсан. Дахин төлөвлөлтийн хүрээнд орон сууц барих ажлыг 2022 оноос эхлүүлнэ. Хугацааны хувьд хүлээгдэж буй асуудал буюу цаашид бүрэн хэрэгжих боломжтой арга хэмжээ байна.

Гарц, шийдэл: 2022 онд бүрэн хэрэгжих боломжтой.

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Д. ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН